

**ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ГАЗРЫН
2026 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН
ТАЙЛАНД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ДҮН**

2026.06.23

Монгол Улсын Засгийн газрын тухай хууль, Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний холбогдох 5 стратегийн зорилго 24 зорилтын хүрээний 35 арга хэмжээний хэрэгжилтийг ханган ажилласан байна.

Тус газрын гүйцэтгэлийн тайланг "Журам батлах тухай" Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан "Байгуулагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам"-ын 2.4, 2.5-т заасан аргачлалаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ. Хүрэх түвшин нь 01-12 сар (жилийн) болж заасан арга хэмжээг хагас жилийн байдлаар үнэлэхдээ зорилтот түвшинг 50%-иар хуваан авч, гүйцэтгэлтэй харьцуулан тооцлоо.

Гүйцэтгэлийн тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийхдээ холбогдох аргачлалын дагуу батлагдсан төлөвлөгөөний шалгуур үзүүлэлт, суурь түвшин, зорилтот түвшинг тус тус харгалзан үзсэн.

Хүснэгт-1

№	Төлөвлөлтийн хэсэг	Зорилтын тоо	Арга хэмжээний тоо	Гүйцэтгэлийн үнэлгээний дундаж хувь /өөрсдийн үнэлсэн/	ХШУДАГ-аас өгсөн үнэлгээ
1	Зорилт 1. "Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2026 оны арга хэмжээний төлөвлөгөө"-г батлуулах, хэрэгжилтэд хяналт тавих	1	1	50%	50%
2	Зорилт 2. Төрийн болон албаны нууцын эрх зүйн зохицуулалтыг шинэчлэн боловсронгуй болгох	1	2	100%	100%
3	Зорилт 3. Олон нийтийн хяналтын тухай хуулийн төслийг боловсруулах	1	1	100%	100%
4	Зорилт 4. Иргэн, аж ахуйн нэгжээс төрд байгаа мэдээллийг шаардахгүй байх мэдээллийн жагсаалтыг гаргаж, эрх зүйн орчныг сайжруулах	1	1	-	Үнэлэх боломжгүй
5	Зорилт 5. Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулан, УИХ-д өргөн мэдүүлэх	1	1	100%	80%
6	Зорилт 6. Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулахад дэмжлэг үзүүлэн, ЗГ-ын хуралдаанд хэлэлцүүлж, УИХ-д өргөн мэдүүлэх	1	1	100%	70%

7	Зорилт 7. Эрдэнэтийн овоо ордын үүсмэл ордыг ашиглаж байгаа хуулийн этгээдүүдтэй төрийн эзэмшлийн хувьцааны хувь хэмжээг тогтоох хэлэлцээг хийх	1	1	-	Үнэлэх боломжгүй
8	Зорилт 8. "Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай хууль", "Нийтийн өмчийн тухай хуулийн" төслүүдийг боловсруулан УИХ-д өргөн мэдүүлэх	1	1	100%	100%
9	Зорилт 9. ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлэх, танилцуулах асуудлыг хянаж, ЗГХЭГ-ын саналыг бэлтгэж, удирдлагыг зөвлөгөө, мэдээллээр хангах	1	2	100%	98%
10	Зорилт 10. ЗГ-аас УИХ-ын ээлжит чуулганаар хэлэлцүүлэхээр өргөн мэдүүлэх хууль тогтоомжийн төслийн жагсаалтыг гарган танилцуулах	1	1	100%	100%
11	Зорилт 11. ЗГ-ын хуралдаанаар хэлэлцэх асуудлын эрх зүйн үндэслэлийг хянан зөвшөөрөл өгөх, ЗГ-ын шийдвэрийг хууль тогтоомжид нийцүүлэн гаргахад зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх	1	1	100%	100%
12	Зорилт 12. ЗГ-ын хуралдааныг хэвийн явуулах бэлтгэл хангах, зохион байгуулах, хуралдааны явцыг баримтжуулах	1	1	100%	100%
13	Зорилт 13. ЗГ-ын хуралдааны шийдвэр, тэмдэглэл, дэлгэрэнгүй тэмдэглэлийг албажуулах, холбогдох байгууллагад хүргүүлэх, архивт шилжүүлэх	1	1	100%	100%
14	Зорилт 14. Ерөнхий сайд, ЗГХЭГ-ын даргын эрхлэх асуудлын хүрээний бие даан боловсруулах хууль тогтоомж, шийдвэрийн төсөлд мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх	1	3	93%	92%
15	Зорилт 15. Засгийн газрын тогтоол, шийдвэрийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах; Хууль тогтоомж, ЗГ-ын шийдвэрийн төсөлд хууль зүйн мэргэжлийн дэмжлэг үзүүлэх	1	3	70%	70%
16	Зорилт 16. Удирдлагын шийдвэрийн дагуу ЗГ, ЗГХЭГ-ыг Үндсэн хуулийн цэц, шүүх, прокурорын байгууллагад төлөөлөх, тайлбар, мэдээллийг бэлтгэн хүргүүлэх	1	3	100%	100%

17	Зорилт 17. МУ-ын харьяат болох, харьяатаас гарах, харьяатаа сэргээж тогтоолгох асуудлыг хянах, Ерөнхий сайдад танилцуулах	1	1	100%	100%
18	Зорилт 18. Хувийн өмчийн халдашгүй байдлыг хамгаалж, бизнесийн үйл ажиллагаанд зүй бусаар нөлөөлөх, хууль бусаар өмч хураах, албадан хариуцлага хүлээлгэхийг хориглох эрх зүйн орчныг бүрдүүлэх	1	1	100%	100%
19	Зорилт 19. Засгийн газрын тогтоол, Ерөнхий сайдын захирамж, сайдын тушаалаар байгуулагдсан ажлын хэсгүүдийг уялдаа, удирдлага зохицуулалтаар хангаж, зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх	1	2	100%	100%
20	Зорилт 20. Хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтийг яам, ЗГ-ын агентлагийн түвшинд уялдуулан зохицуулах, хэрэгжүүлэх үйл ажиллагааны гүйцэтгэлд хяналт тавих	1	1	100%	100%
21	Зорилт 21. Албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулах, хяналт тавих, дижитал шилжилт хийх, тайлагнах	1	1	70%	70%
22	Зорилт 22. Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг хуульд заасан хугацаанд шийдвэрлэх	1	1	93%	93%
23	Зорилт 23. Архив, албан хэрэг хөтлөлтийн журмын дагуу Засгийн газрын хуралдааны болон мэдээ, тайлан, баримтуудыг нэгж, албан хаагчдаас хуваарийн дагуу хугацаанд нь бүрэн шилжүүлэн авах	1	3	100%	100%
24	Зорилт 24. Төрийн байгууллага, албан тушаалтан, нийтийн эрх зүйн этгээдэд тамга, тэмдэг хийлгэх зөвшөөрөл олгох, хяналт тавих, тайлагнах	1	1	100%	100%
Дундаж ерөнхий үнэлгээ		22	33	94%	92%

Хүснэгт-2

Газар, хэлтэс	Зорилтын тоо	Арга хэмжээний тоо	85 буюу түүнээс дээш хувь бол "бүрэн хангалттай" (арга хэмжээ оновчтой тодорхойлогдсон, зорилтот түвшинд нь хүрсэн, удирдлага зохион байгуулалт сайн, үр дүн гарсан, эсхүл шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинд нь бүрэн хүрээгүй, үр дүн гарч эхэлсэн)	70-85 хүртэл хувь бол "хангалттай" (шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинд нь бүрэн хүрээгүй, зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулах)	70 хүртэл хувь бол "хангалтгүй" (удирдлага, зохион байгуулалт хангалтгүй, төсөв хөрөнгийг үр дүнтэй зарцуулж чадаагүй нь баримтаар нотолгоотой.)
ХЭЗГ	22	33	17	4	1

ДҮГНЭЛТ

Хууль, эрх зүйн газраас 2026 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийн тайланг **94%** хувиар үнэлж ирүүлснийг хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж **92%** хувиар үнэлэв.

Газрын гүйцэтгэлийн тайлан бүрэн гүйцэд байсан боловч дараах зорилтуудын үнэлгээг тооцохдоо тусгасан болно: Зорилт 4 болон Зорилт 7 хэрэгжилтийн ХЭЗГ-ын хяналтаас гадуур байгаа тул үнэлэх боломжгүй; Зорилт 5 (Төрийн албаны хуулийн шинэчилсэн найруулга) — УИХ-д шинэчилсэн найруулга хэлэлцэгдээгүй тул 80%; Зорилт 6 (ҮБС-ийн хуулийн дэмжлэг) — Засгийн газрын хуралдаанаар хэлэлцсэн баримт байхгүй тул 70%; Зорилт 15.3 (Давхардал арилгах) — судалгааны шатанд байгаа.

Хууль, эрх зүйн газрын 2026 оны эхний хагас жилд гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан ажлаас онцолбол:

- Төрийн болон албаны нууцын тухай хуулийн шинэчилсэн найруулга болон Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулийн 2 төслийг боловсруулж 2026.03.18-нд УИХ-д өргөн мэдүүлсэн.
- Бизнесийн эрх чөлөөний тухай болон Нийтийн өмчийн тухай хуулийн төслүүдийг боловсруулж УИХ-д өргөн мэдүүлсэн.
- ЗГ-ын тогтоол-250, тэмдэглэл-367, захирамж-134, нийт 751 асуудлыг хянан, ЗГ-ын шийдвэрийг хууль тогтоомжид нийцүүлж, хуралдааны явцыг бэлтгэж, баримтжуулан ажилласан.
- ЗГ-аас санаачилсан 26 хуулийн төслийг УИХ-д өргөн мэдүүлэхэд бүрдүүлбэр болон хууль зүйн үндэслэлийг хянасан.
- Засгийн газар, Ерөнхий сайд, ЗГХЭГ-т холбогдох хэрэгт нийт 47 удаагийн итгэмжлэл олгож, 6 хэрэг, маргаанд итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцон ажилласан.
- 2024-2025 оны архивын 74 ботийн 16,485 хуудас баримтыг цахимжуулж мэдээллийн сан үүсгэсэн;
- 15 хаалттай хуралдааныг зохион байгуулж, 36 нууц асуудлыг журмын дагуу боловсруулж тараасан.


Хууль, эрх зүйн газрын 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнөөс анхаарах шаардлагатай ажлаас дурдвал:

- Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн 2026 оны арга хэмжээний төлөвлөгөө хагас жилийн хугацаанд батлагдаагүй хоцрогдсон байна. Батлуулах ажлыг эрчимжүүлэх шаардлагатай.
- ЗГ-ын шийдвэрийн давхардал, хийдлийг арилгах ажил (Зорилт 15.3) зөвхөн судалгааны шатанд байгаа тул хоёрдугаар хагас жилд тодорхой хуваарь, хэмжилт үзүүлэлтийн дагуу хэрэгжүүлэх шаардлагатай.

ЗӨВЛӨМЖ

- Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн 2026 оны арга хэмжээний төлөвлөгөөг батлуулах ажлыг эрчимжүүлэн ажиллах.
- ЗГ-ын шийдвэрийн давхардал, хийдлийг арилгах ажлын хэсгийг хоёрдугаар хагас жилд тодорхой хуваарь, хэмжилт үзүүлэлтийн дагуу хэрэгжүүлэх.
- Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх хугацааг тодорхойлж, хоёрдугаар хагас жилийн үйл ажиллагааны хуваарьт тусгах.
- Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн дүгнэлт, зөвлөмжийн дагуу зорилтот түвшинд хүрээгүй арга хэмжээг үлдсэн хагас жилийн хугацаанд эрчимжүүлэн ажиллах.

ХЯНАСАН:



ДЭД ДАРГА С.БАТБОЛД

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:



ЗАСГИЙН ГАЗРЫН РЕФЕРЕНТ
Б.ОРГИЛ

Хавсралт

Хүснэгт-3

**ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ГАЗРЫН 2026 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ДҮН
/ЗААЛТ БҮРИЙН ҮНЭЛГЭЭ/**

Арга хэмжээний д/д	Арга хэмжээний дугаар	Өөрсдийн өгсөн үнэлгээ	ХШҮ хийсэн үнэлгээ	Үнэлгээний тайлбар
Зорилт 1. "Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2026 оны арга хэмжээний төлөвлөгөө"-г батлуулах, хэрэгжилтэд хяналт тавих				
1	1.1	50	50	ЗГХЭГ-ын хөтөлбөрийн арга хэмжээний төлөвлөгөө батлагдаагүй байна.
Зорилт 2. Төрийн болон албаны нууцын эрх зүйн зохицуулалтыг шинэчлэн боловсронгуй болгох				
2	2.1	100	100	Хуулийн 2 төслийг 2026.03.18-нд УИХ-д өргөн мэдүүлсэн. Зорилт бүрэн хэрэгжсэн.
3	2.2	100	100	Тайлан дагуу 100% хэрэгжилттэй. Зорилтот түвшинд хүрсэн.
Зорилт 3. Олон нийтийн хяналтын тухай хуулийн төслийг боловсруулах				
4	3.1	100	100	Удирдлагаас "Төр-Иргэний хяналтын тухай" хуульд нэгтгэхээр шийдвэрлэснийг тооцон, хуулийн анхны хувилбар боловсруулж удирдлагад танилцуулсан. Зорилт хэрэгжсэн гэж үнэлэв.
Зорилт 4. Иргэн, аж ахуйн нэгжээс төрд байгаа мэдээллийг шаардахгүй байх мэдээллийн жагсаалтыг гаргаж, эрх зүйн орчныг сайжруулах				
5	4.1	0	Үнэлэх боломжгүй	Холбогдох асуудал нь ЦХИХХ яамны эрхлэх асуудалд хамаарах үнэлэх боломжгүй.
Зорилт 5. Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулан, УИХ-д өргөн мэдүүлэх				
6	5.1	100	80	Нийгмийн баталгааны болон ёс зүйн хуулийн төслүүдийг боловсруулсан боловч "Шинэчилсэн найруулга" хэлбэрээр УИХ-д өргөн мэдүүлсэн баримт байхгүй. Шалгуур үзүүлэлт (УИХ-д өргөн мэдүүлсэн=тийм) хангагдаагүй тул 80% үнэлэв.
Зорилт 6. Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулахад дэмжлэг үзүүлэн, Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлж, УИХ-д өргөн мэдүүлэх				
7	6.1	100	70	ХЭЗГ нь Ерөнхий сайдын 2025 оны 72 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн нарийн бичгийн үүрэг гүйцэтгэж хувилбаруудыг харьцуулан Тэргүүн дэд даргад танилцуулсан. Гэвч хагас жилд ЗГ хуралдаанаар хэлэлцэгдсэн болон УИХ-д өргөн мэдүүлсэн баримт байхгүй тул 70% үнэлэв.
Зорилт 7. Эрдэнэтийн овоо ордын үүсмэл ордыг ашиглаж байгаа хуулийн этгээдүүдтэй төрийн эзэмшлийн хувьцааны хувь хэмжээг тогтоох хэлэлцээг хийх				
8	7.1	0	Үнэлэх боломжгүй	Хэлцлийн явц нь ТХГХАГ болон СБЗГ-ын хариуцлагад хамаарах тул үнэлэх боломжгүй.

Зорилт 8. "Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай хууль", "Нийтийн өмчийн тухай хуулийн" төслүүдийг боловсруулан УИХ-д өргөн мэдүүлэх				
9	8.1	100	100	2 хуулийн төслийг тус тус 2025.01.09 болон 2025.06.24-нд УИХ-д өргөн мэдүүлсэн. Зорилт бүрэн хэрэгжсэн.
Зорилт 9. Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх, танилцуулах асуудлыг хянаж, ЗГХЭГ-ын саналыг бэлтгэж, удирдлагыг зөвлөгөө, мэдээллээр хангах				
10	9.1	100	100	ЗГ-ын тогтоол-250, тэмдэглэл-367, захирамж-134, нийт 751 асуудлыг хянан, албажуулахад дэмжлэг үзүүлж ажилласан (2026.06.05-ны байдлаар). Жилийн зорилтот 1000-ийн 50%-д болох 500-ийг 751-ээр давсан.
11	9.2	100	95	Нийт 19 асуудалд санал бэлтгэн хүргүүлсэн. Жилийн зорилтот 40-ийн 50% болох 20-той харьцуулахад 19/20=95% биелэлт тул 95% үнэлэв.
Зорилт 10. ЗГ-аас УИХ-ын ээлжит чуулганаар хэлэлцүүлэхээр өргөн мэдүүлэх хууль тогтоомжийн төслийн жагсаалтыг гарган танилцуулах				
12	10.1	100	100	2026 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцүүлэхээр өргөн мэдүүлэхээр тогтсон болон өргөн мэдүүлсэн хуулийн жагсаалтыг гарган, тухай бүр шинэчлэн удирдлагад танилцуулж байна. Зорилт хэрэгжсэн.
Зорилт 11. ЗГ-ын хуралдаанаар хэлэлцэх асуудлын эрх зүйн үндэслэлийг хянан зөвшөөрөл өгөх, ЗГ-ын шийдвэрийг хуультогтоомжид нийцүүлэн гаргахад зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх				
13	11.1	100	100	ХЗДХЯ-ын эрхлэх асуудлын хүрээний 18 удаагийн ЗГ хуралдаанаар 52 асуудал хэлэлцүүлж, нийт 59 асуудалд хянан зөвшөөрөл өгсөн. Жилийн зорилтот 59-ийн 50% болох 29.5-аас 59 нь 2 дахин их.
Зорилт 12. ЗГ-ын хуралдааныг хэвийн явуулах бэлтгэл хангах, зохион байгуулах, хуралдааны явцыг баримтжуулах				
14	12.1	100	100	2026 оны эхний хагас жилд нийт 15 хаалттай хуралдааныг зохион байгуулж, 36 нууц асуудлын материалыг журмын дагуу боловсруулж тараасан. Зорилт бүрэн хэрэгжсэн.
Зорилт 13. ЗГ-ын хуралдааны шийдвэр, тэмдэглэл, дэлгэрэнгүй тэмдэглэлийг албажуулах, холбогдох байгуулагад хүргүүлэх, архивт шилжүүлэх				
15	13.1	100	100	Хаалттай хуралдаанаас гарсан 12 тогтоол, 2 захирамж, 26 тэмдэглэл, нийт 40 шийдвэрийг албажуулсан. Жилийн зорилтот 78-ийн 50% болох 39-тэй харьцуулахад 40/39 = 102% — 100% биелэлт.
Зорилт 14. ЕС, ЗГХЭГ-ын даргын эрхлэх асуудлын хүрээний бие даан боловсруулах хууль тогтоомж, шийдвэрийн төсөлд мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх				
16	14.1	100	95	1084 хуудас бүхий 378 эрх зүйн актад товъёог бичиж, ЗГ-ын 22 хуралдаанд хууль зүйн лавлагаа бэлтгэж, Legalinfo.mn-д 109 тогтоол байршуулж,

				1400 картаар лавлагаа өгсөн. Жилийн зорилтот 919-ийн 50% болох 459.5-аас бага (378) боловч 95% үнэлэв.
17	14.2	80	80	Төрийн нууцын тухай (УИХ-д хүргэгдсэн), Хот, тосгоны эрх зүйн байдлын хуулийн 3 өөрчлөлт, стратегийн ашигт малтмалын хуулийн төслийн бэлтгэл, Газрын хуулийн шинэчилсэн найруулгад дэмжлэг — нийт 4 хуулийн төслийг боловсруулж ажилласан.
18	14.3	100	100	ХЗДХЯ-аас боловсруулсан 5 болон ЗГ-ын санаачилгаар боловсруулсан 21, нийт 26 хуулийн төслийг УИХ-д өргөн мэдүүлэхэд бүрдүүлбэр болон хууль зүйн үндэслэлийг хянан ажиллав. Жилийн зорилтот 16-ийн 50% болох 8-аас 26 нь 3 дахин их.
Зорилт 15. ЗГ-ын тогтоол, шийдвэрийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах; хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн төсөлд хууль зүйн мэргэжлийн дэмжлэг үзүүлэх				
19	15.1	100	100	Ерөнхийлөгч, УИХ-ын гишүүний санаачилсан 33 хуулийн төсөлд санал өгсөн ЗГ-ын хуралдааны тэмдэглэлийг хуульсанаачлагчдад хүргүүлэв. Жилийн зорилтот 50-ийн 50% болох 25-аас 33 нь их — 100% биелэлт.
20	15.2	100	100	ЕС-д тавьсан 15 асуулгын хариуг хуульд заасан хугацаанд хүргүүлж ажилласан. Жилийн зорилтот 14-ийн 50% болох 7-оос дээш — 100% биелэлт.
21	15.3	10	10	Хиймэл оюун ашиглан давхардал хийдлийг арилгах аргачлалыг судалж байгаа ба ажлын хэсэг хоёрдугаар хагас жилд байгуулж ажиллуулахаар төлөвлөж байна. ХШУДАГ-ын цуглуулсан мэдээллийг ашиглах боломжийг судалж буй. Хагас жилийн бодит хэрэгжилт 10% тул 10% үнэлэв.
Зорилт 16. Удирдлагын шийдвэрийн дагуу ЗГ, ЗГХЭГ-ыг Үндсэн хуулийн цэц, шүүх, прокурорын байгуулагад төлөөлөх, тайлбар, мэдээллийг бэлтгэн хүргүүлэх				
22	16.1	100	100	Үндсэн хуулийн цэцээс 4 албан бичгийн хариуг бэлтгэн хүргүүлж ажилласан. Жилийн зорилтот 8-ийн 50% болох 4-тэй тэнцэж байна — 100% биелэлт.
23	16.2	100	100	ЗГ, ЕС, ЗГХЭГ-т холбогдох хэрэгт итгэмжлэлийг нийт 47 удаа олгосон нь зорилтот 40-ийн 50% болох 20-оос их — 100% биелэлт.
24	16.3	100	100	6 хэрэг, маргаанд итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцон ажилласан. Жилийн зорилтот 9-ийн 50% болох 4.5-аас их (6) тул 100% биелэлт.
Зорилт 17. МУ-ын харьяат болох, харьяатаас гарах, харьяатаа сэргээж тогтоолгох асуудлыг хянах, Ерөнхий сайдад танилцуулах				
25	17.1	100	100	Харьяатаас гарах хүсэлт гаргасан 35 иргэний баримт бичгийг хянаж Ерөнхий сайдад танилцуулсан.

Зорилт 18. Хувийн өмчийн халдашгүй байдлыг хамгаалж, бизнесийн үйл ажиллагаанд зүй бусаар нөлөөлөх, хууль бусаар өмч хураах, албадан хариуцлага хүлээлгэхийг хориглох эрх зүйн орчныг бүрдүүлэх				
26	18.1	100	100	Бизнесийн эрх чөлөөний тухай хуулийн төслийг боловсруулж 2026.06.03-нд УИХ-д өргөн мэдүүлсэн. Зорилт бүрэн хэрэгжсэн.
Зорилт 19. Засгийн Газрын тогтоол, Ерөнхий сайдын захирамж, сайдын тушаалаар байгуулагдсан ажлын хэсгүүдийг уялдаа, удирдлага зохицуулалтаар хангаж, зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх				
27	19.1	100	100	ЗГХЭГ-ын даргын тушаал-52, Тэргүүн дэд даргын тушаал-372, ЕС-ын албан даалгавар-10, нийт 434 үндэслэлийг хянаж, дэмжлэг үзүүлсэн. Жилийн зорилтот 627-ийн 50% болох 313.5-аас 434 нь их — 100% биелэлт.
28	19.2	100	100	ХЭЗГ-ын албан хаагчид ЗГХЭГ-ын даргын эрхлэх асуудлын хүрээний 12 ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж ажилласан. Жилийн зорилтот 16-ийн 50% болох 8-аас 12 нь их — 100% биелэлт.
Зорилт 20. Хууль тогтоомж, ЗГ-ын шийдвэрийн хэрэгжилтийг яам, ЗГ-ын агентлагийн түвшинд уялдуулан зохицуулах, хэрэгжүүлэх үйл ажиллагааны гүйцэтгэлд хяналт тавих				
29	20.1	100	100	Хууль тогтоомж, ЗГ-ын шийдвэрийн хэрэгжилт, гүйцэтгэлд тухай бүр хяналт тавьж ажиллаж байна.
Зорилт 21. Албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг хуульж урмын дагуу зохион байгуулах, хяналт тавих, дижитал шилжилт хийх, тайлагнах				
30	21.1	70	70	8578 ирсэн бичиг, 3750 явуулсан бичгийг бүртгэж боловсруулж, ирсэн бичгийн 40%, явсан бичгийн 90% цахимжсан; нийт 70%
Зорилт 22. Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг хуульд заасан хугацаанд шийдвэрлэх				
31	22.1	93	93	Нийт 677 албан бичгийн хариутай 406-д 379 нь хугацаанд хариулагдсан (93.3%); 78 өргөдөлгомдлоос 74 нь шийдвэрлэгдсэн (94.9%). Жилийн зорилтот 2496-ийн 50% болох 1248-аас бага (677) боловч 93% үнэлэв.
Зорилт 23. Архив, албан хэрэг хөтлөлтийн журмын дагуу ЗГ-ын хуралдааны болон мэдээ, тайлан, баримтуудыг нэгж, албан хаагчдаас хуваарийн дагуу хугацаанд нь бүрэн шилжүүлэн авах				
32	23.1	100	100	758 хадгаламжийн нэгжийг (байнга 298, түр 460) ЗГ-ын архивт бүрдүүлэлтээр хүлээж авсан. Жилийн зорилтот 1249-ийн 50% болох 624.5-аас 758 нь их — 100% биелэлт.
33	23.2	100	100	2024-2025 оны 74 ботийн 16,485 хуудас баримтыг цахимжуулж мэдээллийн сан үүсгэсэн; Цахим архивын систем хөгжүүлэх тендер шалгарсан, гэрээ байгуулах ажил хийгдэж байна. Зорилтот 100% цахимжилтад хүрсэн.
34	23.3	100	100	Нийт 120 зөвшөөрлийн хүрээний 3475 хуудас, дотоод хэрэгцээний 3170 хуудас, нийт 6645 хуудас баримт. Жилийн

				зорилтот 11598-ийн 50% болох 5799-аас 6645 нь их — 100% биелэлт.
Зорилт 24. Төрийн байгууллага, албан тушаалтан, нийтийн эрх зүйн этгээдэд тамга, тэмдэг хийлгэх зөвшөөрөл олгох, хяналт тавих, тайлагнах				
35	24.1	100	100	175 байгуулагааас хүсэлт ирснийг судалж, 135-д зөвшөөрөл олгон, 40-д буцааж хариу хүргүүлсэн. Монгол бичгийн шаардлагын дагуу 133 байгуулагад зөвшөөрөл хүргүүлсэн. Жилийн зорилтот 100-ийн 50% болох 50-аас 175 нь их — 100% биелэлт.
Нийт дундаж үнэлгээ		94%	92%	Газрын өөрийн үнэлгээтэй харьцуулахад ялгаатай зорилтууд: Зорилт 1 (50%), Зорилт 5 (80%), Зорилт 6 (70%), Зорилт 9.2 (95%), Зорилт 14.1 (95%), Зорилт 14.2 (80%), Зорилт 15.3 (10%), Зорилт 22.1 (93%). Зорилт 4, 7 — үнэлэх боломжгүй.